

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хэл яриан дахь
код солих үзэгдэл

Амарсанаагийн МӨНХЦЭЦЭГ*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Компьютер хэл шинжлэлийн салбар

Received: 10 October 2025 / Accepted: 20 October 2025 / Published: 30 December 2025

Хураангуй: Даяаршиж буй өнөө үед хүүхэд залуус гадаад хэл сурч түүнийгээ өдөр тутмын яриандаа хольж хэрэглэх үзэгдэл түгээмэл болжээ. Энэхүү хэлний үзэгдлийг нийгэм хэл шинжлэлийн үүднээс “код солилт” хэмээн нэрлэж, судалдаг. Код солих үзэгдлийн тухай БНХАУ-д сууж буй монголчууд монгол, хятад хэлний баримт цуглуулан код солих үзэгдлийн талаар судалсан байна. Харин Монгол Улсад одоогоор код солих үзэгдлийг монгол хэлний жишээ баримтад тулгуурлан судалсан бүтээл хараахан нийтлэгдээгүй байна. Тиймээс энэхүү өгүүлэлд Ерөнхий Боловсролын Сургуулийн (ЕБС гэж товчилно) 6-12 дугаар ангийн сурагчдын хэл яриан дахь монгол, англи хэлний код солих үзэгдлийг судалж, түүний хэрэглээний талбар, шалтгаан, төрлийг тодруулахыг зорилго.

Түлхүүр үгс: Код солилт, код холилт, домэйн (талбар), шалтгаан, төрөл

A Study on Code-Switching Phenomena
in the Language of General Education School Students

MUNKHTSETSEG Amarsanaa

Department of Computational Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: In the era of globalization, it has become common for children and young people to learn foreign languages and mix them into their daily conversations. This linguistic phenomenon is studied from the perspective of sociolinguistics and is referred to as code-switching. Regarding code-switching, Mongolians residing in the People's Republic of China have collected data on Mongolian and Chinese and conducted studies on this phenomenon. However, in Mongolia, no research has yet been published on code-switching based on examples of the Mongolian language. Therefore, this article aims to identify the occurrence, usage, reasons, and characteristics of Mongolian-English code-switching in the speech of secondary school students in grades 6 to 12.

* © А. Мөнхцэцэг, 2025, Email: munkhtsetsega@mas.ac.mm



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

1. Удиртгал

Код солилтын талаарх судалгаа 1960-аад оноос эхэлжээ. Хэлний “код солилт” гэх ухагдахууныг Нийгэм хэл шинжлэлийн (НХШ гэж товчилно) эрдэмтэн *Ханс Вогт* (Hans Vogt) 1954 онд хэвлүүлсэн “Language Contacts” (Хэл хоорондын харилцаа) хэмээх номдоо анх дурдсан бөгөөд НХШ-ийн эрдэмтэн *Роман Якобсон* (Roman Jacobson) хэл шинжлэлийн нэр томъёо болгон ашигласан байна. Түүнээс хойш код солих үзэгдлийг *Ж.Фишман* (J.Fishman, 1965), *Ж.П.Блом, Ж.Гумперц* (Blom & Gumperz, 1972, 1986), *К.Майерс-Скоттон* (C.Myers-Scotton, 1993) зэрэг олон судлаач судалж, онолын бүтээлүүдээ гаргажээ. БНХАУ-д сууж буй монголчуудын хэл яриан дахь монгол, хятад хэлний код солих үзэгдлийн талаар *Бао Хиюмин* (Bao Xiuming, 2008), *Оюунтана* (2014), *Бай Наран* (Bai Naren, 2013) нарын магистр, докторын зэрэг горилж бичсэн бүтээл, өөр хэд хэдэн судлаачийн өгүүлэл нийтлэгдсэн бөгөөд манай улс дахь хэлний код солилтын талаар тусгайлан судалсан бүтээл одоогоор үгүй байна.

“*Нийгэм хэл шинжлэл* (sociolinguistics) нь хэл болон нийгмийн харилцааг судалдаг хэл шинжлэлийн салбар ухаан юм. Хүмүүс янз бүрийн нийгмийн нөхцөлд хэлээ хэрхэн хэрэглэж байгааг судлах нь хэл хэрхэн ажилладаг, нийгмийн харилцаа ямар байдлаар бүрэлддэг, мөн хүмүүс хэлээрээ дамжуулан нийгэмд өөрийн дүр төрхөө хэрхэн илэрхийлж, бүтээдэг талаар мэдээлэл өгдөг” (Janet Holmes & Nick Wilson, 2017: 1) байна. Энэ чиглэлийн судалгаанаас үзэхэд, *код солилттой* холбоотой нийгмийн олон хүчин зүйлс байдаг бөгөөд үүнд орчин, нас, хүйс, нийгмийн байр суурь зэрэг орно.

Код солих үзэгдэл нь хоёр болон түүнээс олон хэлтэй хүмүүсийн нийгмийн харилцаанд илэрдэг үзэгдэл бөгөөд хоёр хэлтэй хүмүүс өдөр тутамдаа орчин нөхцөлдөө нийцүүлэн хэлийг хэрэглэх, тодруулбал, тухайн үед хэнтэй, хаана, ямар зорилгоор ярьж байгаагаас шалтгаалан хэлнийхээ хэрэглээг тохируулдаг байна.

Ж.Холмс, Н.Уилсон (Janet Holmes, Nick Wilson) нар код солихтой холбоотой сонирхолтой жишээ татжээ. “АНУ-д амьдардаг япон бүсгүйчүүд Японтой холбоотой “загас”, “шинэ жилийн өдөр” гэх мэт үгийг хэлэхдээ япон хэлээ ашиглах нь илүү хялбар санагддаг байна. Мөн англи хэлтэй оронд сууж буй Гуанжоугаас ирсэн Хятад оюутнууд хоорондоо кантон хэлээр ярьдаг боловч хичээлийн тухай ярилцахдаа англи хэл рүү шилждэг байна. Энэ нь нэг талаар тэд эдийн засаг, хэл шинжлэл, физик гэх мэт мэргэжлийн үгийг англи хэлээр сурсан учраас “*капиталын бүтэц*”, “*морфем*”, “*электрон*” гэх үгийг кантон хэлээр мэдэхгүй байгаатай холбоотой” (2017: 38) гэж тайлбарлажээ. Түүнчлэн “Хүмүүс хоёр дахь хэлээр ярьж байхдаа тухайн хэлээр тохирох үгийг нь мэдэхгүй бол эх хэлнийхээ үгийг сонгож хэрэглэх нь түгээмэл байдаг. Тухайлбал, ярьж байгаа хэлээр нь тухайн ойлголтыг нэрлэсэн тодорхой үг байхгүй бол өөр хэлнээс үг зээлдэж хэрэглэдэг. Ийм төрлийн зээллэг нь ихэвчлэн ганц үг, голдуу нэр үг байдаг” (2017: 44) болохыг тодорхойлсон байна.

2. Судалгааны арга зүй

Бид монгол, англи хэлний код солих үзэгдлийн домэйн (талбар), шалтгаан, төрлийг ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдын хэл ярианы баримтад тулгуурлан судлав. Ажиглалтын хуудас бэлтгэж, дуу хураагуур ашиглан хичээлийн ба хичээлийн бус цагаар ажиглах арга, нээлттэй болон хаалттай асуулт тавих асуулгын арга, хөтөч асуулт бүхий 15-20 минутын ярилцлагын аргаар судалж, баримт материалаа нэгтгэн дүгнэх болон задлан шинжлэх зэрэг хэл шинжлэлийн ерөнхий болон тусгай аргуудыг хэрэглэлээ.

Судалгааны хэрэглэгдэхүүн бүрдүүлэхдээ нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн дунд ахлах бүлгийн 12 ангид хичээлийн болон хичээлийн бус цагаар хөндлөнгийн ажиглалт хийлээ. Мөн 49 сурагчаас асуулгын аргаар анкет бөглүүлсэн ба дуу хураагуурын 20 цаг 40

минутын бичлэгийг судалгааны ажлын гол хэрэглэгдэхүүн болгон ашиглав. Уг судалгааны ажлын эх хэрэглэгдэхүүн цутлуулахдаа зохих журмын дагуу зөвшөөрөл авсан болно.

3. Код солих домэйн (ярианы талбар)

“Код солилтын хэв маягийг хүмүүсийн энгийн харилцан ярианы аливаа талбарт авч үзэх нь тохиромжтой. Үүнийг *домэйн* (domian)¹ гэж нэрлэдэг бөгөөд Ж.Фишман энэ нэр томъёог нийгэм хэл шинжлэлд оруулжээ (Janet Holmes & Nick Wilson, 2017:25). Ж.Фишман “Хэлний сонголт бол нөхцөл байдлаас хамаардаг бөгөөд ямар нөхцөлд аль хэлээр нь ярихыг урьдчилан таамаглаж болно” гээд тэрхүү нөхцөл байдлыг заах үгийг *домэйн* (domain: эзэмшил, салбар/ бүс нутаг) гэж нэрлэх санал дэвшүүлжээ. Энэ нэр томъёо нь цаг хугацаа, орчин нөхцөл, хүний харилцаа зэрэг нийгмийн хүчин зүйлийг багтаасан бидний үйл ажиллагааны цар хүрээг заасан үг бөгөөд энэхүү домэйноос хамаарч аль хэлээр ярилцахаа шийддэг байна. Тэрээр нийгэм хэл шинжлэлийн судалгаандаа гэр бүл, найз нөхөд, шашин шүтлэг, боловсрол, ажлын харилцаа гэсэн 5 домэйныг авч үзсэн байдаг (Janet Holmes & Nick Wilson, 2017:23).

Бидний судалгаа нь ЕБС-ийн орчинд хийсэн ажиглалт учраас *найз нөхөд, боловсрол (ЕБС)* гэсэн домэйны хүрээг хамарч байна. Үүнийг жишээгээр тайлбарлая.

Жишээ 1.

Нөхцөл байдал: А сурагч (6-р анги, эмэгтэй) анги руугаа орж ирэн хүүхдүүдтэй мэндэлсэн. Б сурагч (6-р анги, эмэгтэй) хариулсан.

А: *Hello? (сайн уу?)*

Б: Сайн уу?

Жишээ 2.

Нөхцөл байдал: А сурагч (12-р анги, эмэгтэй) ангийнхандаа баяртай гэж хэлсэн. Б сурагч (12 дугаар анги, эмэгтэй) хариу хэлсэн.

А: Явлаа шүү, *bye bye (баяртай, баяртай)*.

Б: Баяртай.

Жишээ 3.

Нөхцөл байдал: 12-р ангийн эрэгтэй сурагч эрэгтэй найзтайгаа ярьж байна.

А: За байз, юу хийх вэ? *Guys (залуус аа)*.

Б: Маргааш уулзъя.

Жишээ 4.

Нөхцөл байдал: 6-р ангийн эрэгтэй сурагч эрэгтэй найзтайгаа ярьсан.

А: Худлаа хэлсэн ш дээ, bro.

Жишээ 5.

Нөхцөл байдал: 6-р ангийн эмэгтэй сурагч эмэгтэй найзтайгаа ярьсан.

А: Үгүй ш дээ, babe.

Жишээ 6.

Нөхцөл байдал: 6-р ангийн эрэгтэй сурагч эмэгтэй сурагчидтай ангийн хосуудын талаар ярьж байсан.

А: My friends really? (миний найзууд, үнэхээр үү?)

Дээрх жишээнүүдэд тулгуурлан найз нөхдийн *домэйныг* ангийн хүүхэд, эрэгтэй - эмэгтэй сурагч, эрэгтэй - эрэгтэй сурагч, эмэгтэй - эмэгтэй сурагч гэж хүйсээр ангилан авч үзье. Тухайлбал, хүүхдүүд ангийн хүүхэд, найзтайгаа мэндлэхдээ ихэвчлэн код сольж байгааг жишээ

¹ “Домэйн” гэдэг нь шинжлэх ухааны аль салбарт хэрэглэгдэж байгаагаасаа шалтгаалан олон төрлийн ойлголтыг илэрхийлдэг нэр томъёо юм. Жишээ нь, компьютерын салбарт өгөгдөл боловсруулалтыг удирддаг сүлжээний хэсгийг (George McDaniel, 1994:214) хэлдэг. Харин нийгэм хэл шинжлэлд “ярианы талбар” хэмээх ойлголтыг илэрхийлдэг.

1, 2-оос харж болно. Энэ талаар эрдэмтэн Ж.Холмс, Н.Уилсон нар хүмүүс найз нөхөд, гэр бүл, сайн мэдэхгүй хүн, сургуулийн захирал, ажлын газрын дарга зэрэг хүнтэй өөр өөрөөр мэндэлдэг. Ихэнхдээ бие биеэ сайн мэддэг хүмүүс нэрээр нь дууддаг, эсвэл нөхөрсөг үг (*mornin, sweetheart, hello love, hi*) хэрэглэдэг. Дээд тушаалтантай ярихдаа албан ёсны үг, хүндэтгэлийн үг (*Miss Firth, Mr Halliday, Dr Lee*) хэрэглэдэг, эсвэл нэрээс нь зайлсхийж албан ёсны мэндчилгээ (*good morning*) ашигладаг (2017:13) гэжээ. Үүний адил сурагчид багш нартай мэндлэхдээ албан ёсны үг хэллэг (*Сайн байна уу, Багш аа*) ашиглаж, найз нөхөд зэрэг нас ойролцоо хүмүүстэй мэндлэхдээ ихэвчлэн англи үг (*hello, hi*) сонгож байна.

Эрэгтэй сурагчид хоорондоо ярилцахдаа ихэвчлэн *guys* (залуус аа), *bro* (“bro” гэдэг англи үг нь “brother” - ах дүү гэсэн үгийн товчлол бөгөөд ярианы хэлэнд ихэвчлэн найз нөхөд, ойр дотно хүнээ дууддаг найрсаг хэлбэр юм)² зэрэг үгээр *код сольсон* бөгөөд дээрх жишээнээс гадна сурагчид *All good homie? (Homeboy / homegirl)*³ (Зүгээр дээ, найз аа), *Why me? Bro? (Яагаад би гэж найз аа)*, *No, bro (Үгүй, найз аа)*, *What are you doing, bro? (Чи юу хийж байгаа юм бэ, найз)*, *Are you mean understanding, bro? (Чи утгыг нь ойлгож байна уу, найз)*, *I dont like you, bro? (Би чамд дургүй байна, найз)* гэх мэтээр дотно байгаагаа илэрхийлж байна.

Харин жишээ 5-ыг харвал, эмэгтэй сурагчид хоорондоо *babe, Pookie* (сайн найз эсвэл чухал хүнээ ингэж дууддаг нэршил)⁴ гэх үгээр бие биеэ дуудаж, дотно байдлаа илэрхийлж байна. Жишээ 6-г харвал, эрэгтэй, эмэгтэй сурагчид хоорондоо харилцахдаа *friend* (найз гэх утгатай ба албан бичиг, ярианы хэлэнд хэрэглэдэг үг)⁵ гэх үгийг ашигласан байна. Ингэж хүйсээс хамааран өөр өөр үг хэрэглэн *код сольж* байна. Сургуулийн орчинд найз нөхдийн болон боловсролын домейнд код солилт ихэвчлэн монгол-англи хэлээр илэрч байна.

Асуулгын аргын судалгаанд 49 сурагч (47 сурагчийн эх хэл нь монгол хэл, 1 сурагчийн эх хэл нь солонгос, 1 сурагчийн эх хэл нь англи) оролцсон бөгөөд дараах хоёр асуултын хариуг авч үзвэл:




График 1. Монгол хэлээр ярихдаа гадаад үг ашигладаг эсэх тухай асуултын хариулт

30 (61%) нь ихэвчлэн, 18 (37%) нь заримдаа, 1 (2%) нь огт ашигладаггүй гэж хариулсан буюу олонх сурагч өдөр тутмын яриандаа гадаад үг, хэллэгийг ашигладаг байна. Иймд дараагийн асуултаар гадаад хэлээр хаана, хэнтэй харилцдаг талаар тодруулбал:

² <https://www.oxfordlearnersdictionaries.com/>

³ <https://www.oxfordlearnersdictionaries.com/>

⁴ <https://www.oxfordlearnersdictionaries.com/>

⁵ <https://www.oxfordlearnersdictionaries.com/>



График 2. Гадаад үгээр ямар нөхцөлд, хэнтэй харилцдаг тухай асуултын хариулт

сурагчид найзуудтайгаа байхдаа (41 сурагч буюу 84%) болон сошиал орчинд (39 сурагч буюу 80%) гадаад үгийг хамгийн их хэрэглэдэг. Түүнчлэн ангидаа (26 сурагч буюу 53%), гэртээ (24 сурагч буюу 49%), дунд зэрэг, дэлгүүрт (1 сурагч буюу 2%), гадаадад буюу англиас өөр хэлтэй улс оронд (1 сурагч буюу 2%) байхдаа харьцангуй цөөн англи үг хэллэг хэрэглэдэг байна.

4. Код солилт ба ормол үгийн хэрэглээ

“Аливаа хэлний үгийн санд 1. Гадаад үг (foreign words), 2. Олон улсын чанартай үг (Internationalism), 3. Ормол буюу зээлдсэн үг (Loan words, borrowed words) 4. Хуулбар үг, хуулбарласан хэлбэр (calque, borrowed forms) гэсэн хэв маягтай харь үг орж ирж хэлний хөгжлийн явцад зарим нь хуучирч гээгдэх, тухайн хэлний үгийн санд нутагшин идэвхтэй үгийн нэгж болж гадаад үгийнхээ хэлбэр, агуулгыг хадгалах зэргээр харилцан адилгүй үүрэгтэй байдаг” (Мөнхцэцэг нар, 2023: 3). Тиймээс, бид өдөр тутмын амьдралдаа ормол үгийг нэлээд хэрэглэдэг боловч тэр нь код солилт болохгүй. Тэгвэл хос хэлтэн (bilingual) болон эх хэл (төрөлх хэл), гадаад хэлийг (эх хэлний дараа сурсан хэл) хольж хэрэглэх тохиолдлыг юу гэж нэрлэвэл зохих вэ?

Ормол үг гэдэг бол тухайн хэлний авиа зүй, хэл зүй, үгийн сангийн хууль зүй тогтолд уусан нийцсэн, зөв бичих дүрэм, зөв дуудах зүйд тохирч хэлбэржсэн үгс юм. Харин “хэлний код солилт гэдэг нь хэлний хэрэглээнд хувиралт ихтэй байдаг нэг хэлбэр болно” (Оюунтана, 2017: 42)”.

Хүснэгт 1. Ормол үг ба код солилтын ялгаатай тал

Ормол үг	Код солилт
<i>Жишээ 1.</i> А: Чөлөөт цагаараа найзуудтайгаа юу хийдэг вэ? Б: Хөвгүүд <i>ПС</i>, охидууд <i>караоке</i> ордог. <i>Жишээ 2.</i> <i>Аирдропоо</i> асаа. <i>Блютүүтээ</i> асаачих.	<i>Жишээ 1.</i> Би <i>longdistance</i>-д ороод аймаар <i>toxic</i> болоод <i>finally</i> би <i>move on</i> хийсэн.
Харь хэлнээс авсан боловч тус хэлний үгийн сангийн системд шингэн орсон.	Ярианы орчинд түр зуур нэг хэлнээс нөгөө хэл рүү шилжүүлж хэрэглэдэг.

Шууд утгаар, тухайн ойлголтыг илэрхийлэх шаардлагатай тохиолдол бүрд тогтвортой хэрэглэгддэг.	Ухамсартай ба ухамсаргүйгээр бусад хэлний үгийг түр зээлэн хэрэглэнэ. Давтамжаар ялгаатай.
Өөр үгээр солин хэлэх боломжгүй (кофе, пицца гэх мэт).	Тухайн ойлголтыг заасан монгол үг байсаар байтал оронд нь гадаад үг хэрэглэдэг.

5. Код солих шалтгаан

“Фэрк, Каспер, Сёндергоорд, Вордхо (Faerch Kasper, Søndergaard, Wardhaugh) нарын судлаачид код солилтын олон шалтгааныг судалсан байдаг. Тэд *ерөнхийдөө үгийн сангийн дутагдал (vocabulary), сайн дурын код солилт (voluntary switching), тохиромжтой байдал (convenience), нэгдмэл байдал (solidarity), ойр дотно байдал (intimacy), илүү тод илэрхийлэл (clearer expression), өөрийн онцлогийг харуулах (identity emphasis)* зэрэг шалтгаан байдаг гэж үзсэн. Жишээ нь: монгол, хятад хэлний код солилтыг авч үзвэл өдөр тутмын харилцан яриандаа тэд үгийн сангийн дутагдлыг нөхөхийн тулд код сольдог. Өөр нэг шалтгаан нь яригчид код солилтыг өөрсдийн санаачилгаар ашигладаг явдал юм. Тэд код солилтыг ашиглах эсэхийг өөрсдөө шийддэг бөгөөд үүнийг *сайн дурын код солилт* гэнэ” (Bai Naren, 2017: 23). Монголын ЕБС-ийн сурагчдын код солилтыг бид судлаад, дараах шалтгаануудыг тодруулав.

5.1. Сайн дурын код солилт

Сёндергоорд сайн дурын код солилтыг “Ярианы үйл явцад ашиглагдаж буй бусад кодоос гарсан үгс нь гол кодоод бүрэн уусдаг нарийн төвөгтэй код солилт юм” хэмээн тодорхойлсон байдаг. Тиймээс энэ нь яригч өөрийн хүслээр, өөрт буй бүх хэлний чадамжийг бүрэн ашиглах замаар илэрдэг ба зарим тохиолдолд хэлний бүтээлч байдлын нэг хэлбэр байж болдог. Мөн ийм сонголт хийх шалтгаан нь олон хэлний кодыг зэрэг ашиглах хүсэл эрмэлзлээс үүдэлтэй байна. Хоёр хэлний хооронд чөлөөтэй шилжих, тухайн нөхцөлд тохирсон хэлний хэрэглээг сонгодог хэмээн үзсэн байна (Ephie Konidaris, 2004:32). Тэгвэл ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын сайн дурын код солилтыг жишээгээр тайлбарлая.

Жишээ 1.

А: За за, зүгээр *joke* (тоглоом, наргиан) байсан юм аа.

Энэ тохиолдолд “тоглоом” гэх англи үгийг монгол хэлний өгүүлбэрийн дунд ашигласан бөгөөд монгол хэлээр “Тоглосон юм аа” хэмээн илэрхийлж болох байтал англи үгийг сонгосон нь сайн дурын код солилт болно.

Жишээ 2.

А: Хөөрхөн цэнхэр дээл өмсчихсөн *match* (зохицох, тохирох, ижил байх) болчихсон байна ш дээ.

Энэ тохиолдолд 12-р ангийн сурагчид урлагийн үзлэгийн бичлэгийг ухраан үзэж байхдаа эрэгтэй, эмэгтэй сурагчид ижил дээл өмсөөд хосолсон байна гэх утгыг илэрхийлэхийн тулд тухайн нөхцөлд тохирсон үгийг ашиглажээ.

5.2. Ойр дотно байх код солилт

Яригч нь хүмүүсийн анхаарлыг татах, нийгмийн байр сууриа илэрхийлэх, ойр дотно харилцаж байгаагаа харуулах зорилго шалтгаанаар хэлний код солилт хийдэг. Хоёр ярилцагч нь гуравдагч этгээдэд ярианы агуулгыг мэдүүлэхгүй нууцлах үүднээс түүний мэдэхгүй хэлээр ярих нь бас хэлний код солилт юм. Танил бус хоёр хүн анх уулзахдаа баримжаа авиагаар ярилцах ба нэг нутгийн хүн гэдгээ мэдвэл нутгийн яриагаар код сольдог (Оюунтана, 2017: 52). Тэгвэл ЕБС-ийн сурагчдын ойр дотно байх шалтгаанаас үүдсэн код солилтыг жишээгээр тайлбарлая.

Жишээ 1.

А: Танай *bestie*-нүүд (*сайн, дотно найз*) чинь хаашаа явсан юм бэ? Яахаар гарав?

Б: Мэдэхгүй

Энэ тохиолдолд эрэгтэй сурагч эмэгтэй сурагчаас дотно найзалдаг найзуудыг нь хаана байгааг асуухдаа түүнтэй ойр дотно найзалдаг болохыг батлан тодруулсан үгээр асуусан байна.

Жишээ 2.

А: Гортиг байна уу? *Guys* (*залуус аа*).

Б: Байхгүй

Энэ тохиолдолд эрэгтэй сурагч ангийн хүүхдүүдээс уг асуултыг асуухдаа ойр дотно байгаагаа илэрхийлэн өөрт хэрэгтэй зүйлээ сурагласан байна.

5.3. Хөгжилтэй байх код солилт

Яригч нь ярианы уур амьсгалыг хувируулах, яриаг улам инээдэмтэй болгох, утгыг тайлбарлах, ойлгуулах шалтгаанаар код солилт үүсдэг (Оюунтана, 2017: 52). Жишээ нь:

Жишээ 1.

А: Уруул руу чинь харчихлаа *sorry* (*уучлаарай*)!

Б: *Stanley* (*нэршил*).

Энэ жишээн дэх үгс нь “Тэнгисийн эрэг дээрх 24/7” шоу нэвтрүүлгийн 1, 2-р бүлэгт гарсан онцлох үг бөгөөд олонд хөгжилтэй байдлаар алдаршсан үг юм. Учир нь “*sorry*”, “*Stanley*” гэх үгийг тухайн нэвтрүүлгийн оролцогчид утгын өргөлттэй хэлснийг олон нийт хөгжилтэй байдлаар түгээмэл хэрэглэх болсон байна. Үүнээс үүдэн сурагчид хөгжилтэй нөхцөл байдалд уг үгсийг хэрэглэсэн. Мөн тэдний үздэг нэвтрүүлэг зэрэг сошиал орчин дахь үг хэллэгийг хоорондоо шууд хэрэглэх нь түгээмэл ажиглагдаж байна.

Жишээ 2.

А: *What's your problem, man* (*ямар асуудал байна вэ, залуу*).

Б: *Money money, cash* (*мөнгө, мөнгө, бэлэн мөнгө*).

А: *I give you* (*би чамд өгье*).

Энэ жишээнд 12-р ангийн эрэгтэй сурагчид хөгжилтэй байхын тулд код солилт хийсэн бөгөөд “*problem*” гэх үгийн эхний үеийг уртаар дуудан хоорондоо харилцан ярилцаж нэгнийгээ инээлгэв.

5.4. Дагаж ярих код солилт

Хүнийг дагаж ярьснаас болж код солилт үүсдэг. Тухайлбал, нөгөө этгээд нь ярианы дунд код сольсон байвал, түүнийг даган код солих үзэгдэл бий болдог (Оюунтана, 2017:47). Жишээ нь:

Жишээ 1.

А: *Why is this?* (*Яагаад энэ вэ?*)

Б: *Why is this?* (*Яагаад энэ вэ?*) Чи юуг нь хараад байгаа юм.

Энэ тохиолдолд 6-р ангийн 2 эмэгтэй сурагч ярьсан бөгөөд нэг сурагч нь эхэлж код солиход дараагийн сурагч даган код сольж байна.

Жишээ 2.

А: *I know your boyfriend* (*би чиний найз залууг мэднэ*), *i know your girlfriend* (*би чиний найз охиныг мэднэ*).

Б: *I know your crush* (*би чиний харж явдаг хүнийг мэднэ*).

Энэ тохиолдолд эмэгтэй найз нь код сольсноос үүдэн эрэгтэй найз нь даган код сольж байна.

5.5. Зорилготой код солилт

Зорилготой код солилт буюу тухайн тохиолдолд аль хэл илүү тохиромжтой байна, тэр хэл рүү код солих үзэгдэл нь ЕБС-ийн сурагчдын хэл ярианд дараах байдлаар илэрч байна.

Жишээ 1.

А: Та нар надаас юм нуугаад байгаа юм бэ?

Б: Үгүй ээ, *joke (тоглоом)* 4 сарын 1.

Энэ нь 6-р ангийн хүүхдүүд завсарлагааны цагаар ярилцаж байсан тохиолдол бөгөөд “тоглоом” гэдэг үгийг хэлсний дараа өөрийн эх хэлээр “4 сарын 1” гэх үгээр бататгасан нь тухайн тохиолдолд тухайн утгыг илүү тохиромжтойгоор илэрхийлэх хэл рүү код сольсон үзэгдэл байна.

Зорилготой үүсэх код солилтод үе тэнгийнхэн нь хэлдэг үгийг хэрэглэх явдал бас хамаардаг бөгөөд ЕБС-ийн сурагчдын хэл ярианд дараах байдлаар илэрч байна.

Жишээ 1.

А: Арай л *toxic (хортой)* байна аа. Салчхаагүй юм уу?

Энэ тохиолдолд “хортой” гэх үгийг эмэгтэй найзууд хосуудын тухай ярилцаж байхдаа хэрэглэсэн. Сурагчид ихэвчлэн хосын харилцаанд “хортой охин/залуу” гэдэг утгаар түгээмэл хэрэглэж байна.

Жишээ 2.

А: Гортиг байна уу? *Guys (залуус аа)*.

Энэ жишээнд “залуус аа” гэх үгийг эрэгтэй сурагч ангийнхаа хүүхдүүдээс юм асуухдаа хэрэглэсэн бөгөөд ЕБС-ийн сурагчид “найз аа, залуус аа” гэхээс илүү англи үгээр ингэж хэлэх нь түгээмэл байна.

Жишээ 3.

А: Надад өгөөч, *please (гуйя)*.

Энэ жишээнд “гуйя” гэх үгийг эрэгтэй сурагч найзаасаа гоймон гуйхдаа хэрэглэсэн бөгөөд ЕБС-ийн сурагчид “гуйя” гэдэг үг хэлэхгүй, англи хэлээр ингэж хэлэх нь маш түгээмэл байна.

Ийнхүү, ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын код солилт нь сайн дурын үүднээс, ойр дотно байх үүднээс, хөгжилтэй байх үүднээс, дагаж ярихаас, тухайн нөхцөлд аль тохиромжтой гэж үзсэн хэлээ сонгох, үе тэнгийнхэн нь хэлдэг үгийг хэлэх гэсэн 5 төрлийн шалтгаанаас үүдэлтэй байна. Мөн тэд өөрсдийн үздэг нэвтрүүлэг, сошиал орчинд түгээмэл хэрэглэдэг англи үгсээр хоорондоо ярих нь их байна.

6. Код солилтын төрөл

6.1. Нөхцөл байдлын код солилт

Ж.П.Блом, Ж.Гумперц нар нөхцөл байдлын код солилтыг яриа эсвэл орчны өөрчлөлтөөс шалтгаалан үүсдэг ба тухайн нөхцөл байдал өөрчлөгдсөн үед хийгддэг шилжилт юм гэжээ. Жишээ нь: шинэ оролцогч ярианд орж ирэх үед, ярианы сэдэв солигдох үед, харилцан яриа шинэ орчинд шилжих үед үүсдэг (Erman Boztepe, 2003:11) байна. Монголын ЕБС-ийн сурагчдад дараах байдлаар илэрч байна.

Жишээ 1.

А: *What is (гэж юу вэ) эх хэл?*

Б: Төрсөн улсын хэл, тэгвэл монгол хэл.

А: *What is (гэж юу вэ) голч?*

Б: Аль хэлний үгийг голчилж хэрэглэдэг вэ? гэсэн үг.

Энэ тохиолдолд 6-р ангийн эрэгтэй сурагчид Араб улсын тухай ярьж байсан бөгөөд ярианы сэдэв өөрчлөгдөж асуулга бөглөх болоход код солилт хийж байна.

6.2. Хаяг шошгын код солилт

Рэнэ Анпел (René Appel), Питер Мюйскен (Pieter Muysken) нарын тодорхойлсноор, хаяг шошгын код солилт нь тухайн өгүүлбэрийн үндсэн хэсгээс ялгаатай хэл дээр илэрхийлсэн дуу алдалт (exclamation), тэмдэг үг (tag), оруулбар үг (parenthetical) зэргийг багтаадаг. Жишээлбэл, өгүүлбэрийн эхэнд байрлах “Oye, when...” гэх мэт хэллэг юм. Ийм төрлийн код солилт нь нэг хэлээр бичсэн өгүүлбэрт хос хэлтний шинж чанарыг илтгэх илэрхийлэл болдог. Дуу алдалт (exclamation) гэдэг нь хүн гэнэт гайхах, гуниглах эсвэл өвдөх үед хэрэглэдэг “oops!”, “wow!”, “of course!”, “no way!” гэх мэт үг юм (Putu Findi Desi Wibiani, 2021: 300) хэмээн үзжээ. Тэгвэл ЕБС-ийнхны хэл ярианд дараах байдлаар илэрч байна.

Жишээ 1.

А: *Oh my god! (Өө, бурхан минь!),* дэвтрээс 100 төгрөг гарлаа.

Жишээ 2.

А: *Oh my god! (Өө, бурхан минь!),* Д-ыг (хүний нэр) ганцааранг нь гаргах байсан юм.

Энэ хоёр тохиолдолд 6-р ангийн эмэгтэй сурагч өөрийн сэтгэл хөдлөлөө илэрхийлэхдээ англи үг хэрэглэсэн байна.

Жишээ 3.

А: *Vibe (ярианы уур амьсгал)* нийлж байна гэж ярьдаг уу?

Б: *Nahh, so cringe (үнэхээр эвгүйцмээр).*

Энэ жишээнд 6-р ангийн эрэгтэй сурагч асуултад хариулахдаа таагүй мэдрэмжээ илэрхийлэхийн тулд код солилт хийсэн байна.

Жишээ 4.

А: Яг миний *type (төрөл, хэв маяг)* байна тэх үү? *Oh my god! (өө, бурхан минь!).*

Энэ жишээн нь НХШ-ийн эрдэмтэн *Саны (San, 2009)* “Тодорхой сэдвээр ярьж байх үед хүчтэй сэтгэл хөдлөл оролцвол код солилт илүү их бүртгэгддэг” (Shafiyah Mohamad Khalil & Firdaus, 2018: 31) гэсэн үзэлтэй таарч байна. Хөндлөнгийн үг (Interjections) нь ихэвчлэн сэтгэл хөдлөл илэрхийлдэг “nahh, omg, damn” зэрэг юм. Сурагчид сэтгэл хөдлөлөө илэрхийлэх үедээ код солилт хийж, байрын хувьд өгүүлбэрийн эхэнд, эсвэл төгсгөлд ихэвчлэн тохиолдож байна.

6.3. Өгүүлбэр доторх код солилт

“Өгүүлбэрийн доторх код солилт нь хоёр ба түүнээс дээш хэлээр ярьдаг хүмүүсийн дунд тохиолддог хэлний үзэгдэл бөгөөд нэг өгүүлбэрийн хүрээнд эх хэл болон хоёр дахь хэлийг ээлжлэн ашигладаг. Энэ нь үгсийг өөр хэлний өгүүлбэр зүйн хүрээнд нэгтгэн оруулж, нэг хэлийг нөгөөгөөр бүрэн сольсон гэсэн үг биш юм (Fernandette & T.Gamotin, 2021:42). ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын өгүүлбэр доторх код солилтыг жишээгээр тайлбарлая.

Жишээ 1.

А: Ковид-19 гээд найз байгаагүй.

Б: Өө, жинхэнэ *fail fail (бүтэлгүйтэл, бүтэлгүйтэл).*

Энэ жишээнд “бүтэлгүйтэл” гэх англи үгийг 12-р ангийн эрэгтэй сурагч оюутан багштай ярилцаж байхдаа өгүүлбэрийн дунд хэрэглэж код сольсон байна.

Жишээ 2.

А: *Who is* (хэн бэ) Б (хүний нэр) багш?

Энд 6-р ангийн эмэгтэй сурагч “Б багш гэж хэн бэ?” гэдэг асуух өгүүлбэрийг хэлэхдээ англи хэлний өгүүлбэр дотор монгол үг оруулсан байна.

Жишээ 3.

А: Ө (хүний нэр) *understand?* (ойлгож байна уу)

Ингэж 6-р ангийн эрэгтэй сурагч англи хэлний хичээл орж байх үед найзаасаа асуусан бөгөөд тухайн англи үгийг монгол хэлний “ойлгож байна уу” гэх үйл үгийн байранд хэрэглэсэн байна.

Жишээ 4.

А: Багш ингэдэг бол яах уу? 100 төгрөг өгөөд хариултад нь ундаа аваад ир гээд.

Б: Багш аа эд нартай ярихад ямар байна. Бид нартай ярихаас илүү.

С: Настир алга гэсэн.

Б: Чи дуугай бай гоймон толгойт чинь.

А: Аягүй аймаар *beef-тэй* (зөрчилдөөн) байна шүү.

Энэ тохиолдолд 12-р ангийн сурагчид ярилцаж байсан бөгөөд “beef” гэдэг үг нь “үхрийн мах” гэсэн утгатай боловч уг ярианд “зөрчилдөөн” гэдэг шилжсэн утгыг илэрхийлсэн байна.

Жишээ 5.

А: Та хоёр ямар *toxic* (хортой) юм бэ? *Toxic-моод* байгаарай.

Энэ жишээнд “хортой” гэх үгийг 12-р ангийн эмэгтэй сурагч хоёр эмэгтэй найзыгаа шоглох маягаар өгүүлбэрийн дунд монгол хэлний тэмдэг нэрээс үйл үг бүтээх дагавар залгаж хэрэглэсэн байна.

Жишээ 6.

А: *God* (бурхан), баахан *spoiler* (үйл явдлыг урьдчилан мэдэх) л үзээд байна даа.

Энэ тохиолдолд 12-р ангийн эмэгтэй сурагч “Тэнгисийн эрэг дээрх 24/7” шоу нэвтрүүлгийн үзэж амжаагүй дугаарын хэсгийг фэйсбүүкийн бичлэг гүйлгэн үзэж байхдаа “бурхан” гэх үгээр сэтгэл хөдлөлөө илэрхийлж, “spoiler” гэх үгийг өгүүлбэрийн дунд хэрэглэсэн байна.

Бидний судалгаагаар, ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын өгүүлбэр доторх код солилтын хэрэглэдэг хамгийн түгээмэл дараах үгс байна. Үүнд:


Хүснэгт 2. ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын өгүүлбэр доторх код солилтын хэрэглээ

№	Үг	Үгийн утга	Жишээ өгүүлбэр
1	Eye contact	Харц тулгарах, нүдээр харилцах	<i>Eye contact</i> хийсэн.
2	Red flag	Шууд орчуулбал “улаан туг” гэсэн утгатай боловч энэ хэллэгээр “анхааруулга, болгоомжлох хэрэгтэй дохио” гэсэн утгыг заадаг.	Наадах чинь <i>red flag</i> шүү.
3	Toxic	“Хортой, хөнөөлтэй, үхэлд хүргэх аюултай” гэсэн утгатай үг. Харин хүмүүс “хортой харилцаа, сэтгэл зүйн хувьд ядрааж, хохирол учруулдаг” гэсэн утгаар хэрэглэдэг.	Би <i>longdistance-д</i> ороод аймаар <i>toxic</i> болоод <i>finally</i> би <i>move on</i> хийсэн.

4	Vibe	Үндсэн утга нь “мэдрэмж, уур амьсгал” гэсэн ойлголтыг илэрхийлдэг бөгөөд “чичиргээ” гэсэн үгнээс гаралтай. Ихэвчлэн хүн, газар орчин, нөхцөл байдлыг мэдрэх мэдрэмж, сэтгэгдлийг илэрхийлдэг.	Тэр хэдтэй <i>vibe</i> нийлдэг.
5	Stalk	Нууцаар дагах, араас нь мөрдөх, мөшгөх	<i>Stalk</i> хийгээд байх юм аа.
6	Crush	Үндсэн утга нь “шахцалдах, дарах, няцаах” юм. Харин хүүхэд залуусын дунд “дурласан хүн, сэтгэл татсан хүн, таалагдсан хүн” гэх утгаар хэрэглэгдэж байна.	Тэр миний <i>crush</i> , бүр аймаар <i>cute</i> .
7	Type	Төрөл, хэв маяг, хэв шинж	Чиний <i>type</i> ямар вэ?
8	Hate	Үзэн ядалт, жигшил, дайсагнал	Надад маш их <i>hate</i> ирээд байна.
9	Legend	Домог /нэр хүндтэй, алдартай хүн/	Би бүгдийг чаддаг ёстой <i>legend</i> юм аа.
10	Hangout	Хэн нэгэнтэй хамт цагийг өнгөрөөх	Хэдүүлээ <i>hangout</i> хийх үү?
11	Cringe	Ичмээр, эвгүй санагддаг зүйл	Чи ямар <i>cringe</i> юм бэ?
12	Trauma	Сэтгэлийн шарх, сэтгэл зүйн цочрол, гэмтэл	Тэр надад аймаар <i>trauma</i> өгөөд.
13	Joke	Тоглоом, хошигнол, онигоо	За найзаа <i>joke</i> шүү дээ.
14	Get out	Гар!, гараад яв!	Миний ширээнээс <i>get out</i> .
15	Inspiration	Урам зориг, сэдэл тэмүүлэл	Хаанаас <i>inspiration</i> авдаг вэ?
16	Repost	Дахин нийтлэх, дахин хуваалцах, шинээр нийтлэх	Чи миний <i>repost</i> үзсэн үү?
17	Insecure	Сэтгэл зүйн хувьд өөртөө итгэлгүй	Өөрийгөө <i>insecure</i> хийгээд байна.
18	Research	Мэдээлэл цуглуулах, ямар нэг зүйлийн талаар илүү ихийг мэдэх зорилготой судалгаа	Би Тик Ток ухаж байгаад <i>research</i> хийгээд.
19	Opium	Голчлон хар өнгөтэй, нэвсгэр, сул загвар	Ямар <i>opium</i> банди вэ?
20	Mean	Бүдүүлэг, харгис, хорон	Чи нээрээ мэдэх үү? Тэр охин аймаар <i>mean</i> бас <i>bully</i> юм байна лээ.
21	Upset	Сэтгэл тавгүй, гомдсон, бухимдсан	Би аймаар <i>upset</i> байна.
22	Glowup	Гоё сайхан болох, өөртөө илүү итгэлтэй, үзэсгэлэнтэй болох	Би 9 сарын 1-нд аймаар <i>glowup</i> хийж үзүүлэх үү?

ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын өгүүлбэр доторх код солилтын төрлийг авч үзвэл:

ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдын өгүүлбэр доторх код солилтын төрөл



- Монгол хэлний өгүүлбэрийн бүтцэд англи үг хэрэглэсэн
- Англи хэлний өгүүлбэрийн бүтцэд монгол үг хэрэглэсэн
- Англи үгэнд монгол хэлний дагавар, нөхцөл залгасан

График 3. Өгүүлбэр доторх код солилтын төрөл

Бидний судалгаанд ЕБС-ийн сурагчдын хэлний код холилтын 116 өгүүлбэр бүрдсэнээс монгол хэлний өгүүлбэрийн бүтцэд англи үг хэрэглэсэн 95 өгүүлбэр (82%), англи хэлний өгүүлбэрийн бүтцэд монгол үг хэрэглэсэн 3 өгүүлбэр (3%), англи үгэнд монгол дагавар, нөхцөл залгасан 18 өгүүлбэр (15%) байна. Үүнээс үзвэл, монгол хэлний өгүүлбэрийн бүтцэд англи үг хэрэглэх нь түгээмэл байна. Өгүүлбэрт англи хэлний нэр үг, үйл үгийг ихэвчлэн хэрэглэсэн бөгөөд англи үгэнд монгол дагавар, нөхцөл залгах нь “Хэлний код солилт дахь үг нь уугуул хэлний дагавар залгах аргаар харилцаанд үйлчилдэг (Оюунтана, 2017 43-44)” гэсэн судлаачийн дүгнэлттэй нийцэж байна. Учир нь, хүмүүс код солихдоо ерөнхий өгүүлбэр, эх (text)-ээ эх хэлээрээ хэлж, үг, богино өгүүлбэр зэрэг бага нэгжийг гадаад хэлнээс авч хэрэглэдэг. Бидний судалгаанд судлагдсан хүүхдүүдийн эх хэл нь монгол хэл, харин хоёрдогч буюу сүүлд сурсан хэл нь англи хэл гэдэг нь дээрх үзүүлэлтээс шууд харагдаж байна.

6.4. Өгүүлбэр хоорондын код солилт

Өгүүлбэр хоорондын код солилт гэдэг нь хоёр өөр өгүүлбэрийн хоорондох код солилт бөгөөд эхний өгүүлбэр нь яригчийн үндсэн хэлээр, дараагийн өгүүлбэр нь хоёр дахь хэлээр илэрдэг. *Пумер Мюскен* энэ төрлийн код солилтыг нэг ярианы доторх хоёр өгүүлбэрийн хооронд шилждэг гэж тодорхойлсон байна. *Марзиех Хадей (Marzeih Hadei)*, *Вигнесвари Кристи Кумар (Vigneswari Christie Kumar)*, *Шух Жу (Shuh Jie)* нар өгүүлбэр хоорондын солилт нь дараах хэд хэдэн шалтгаанаас үүддэг (Shafiyah Mohamad Khalil & Firdaus, 2018: 30) гэж үзжээ. ЕБС-ийн 6-12 ангийн сурагчдын ярианд өгүүлбэр хоорондын код солилт дараах байдлаар илэрч байна.

Жишээ 1.

А: Энэ чинь college-д ⁶(их сургууль) явдаг эгч, багш гэж тооцохгүй.

Б: Багш шүү дээ.

А: Social interaction (харилцах чадвар).

Б: Social interaction (харилцах чадвар)

С: You don't social intraction (Чи харилцах чадвар гэж мэдэхгүй).

А: Инээ дээ эгч ээ, адилхан байна.

Энэ тохиолдолд 6-р ангийн эрэгтэй сурагч өөр өөр сонсогчдод хандан ярих үүднээс өгүүлбэр хоорондын код солилт хийж байна. Түүнчлэн “social interaction” гэдэг үг нь нийгмийн харилцаа буюу шилжсэн утгаар, хүмүүстэй харилцах чадвар гэсэн утгатай. А сурагч шог хэллэг болгон утга шилжүүлэн ярьсан бол Б сурагч энэ үгийг давтан хэлж хариу барьсан. Харин С сурагч “чи хүнтэй харилцах чадвар гэж мэдэхгүй” гэх байдлаар хоорондоо утга шилжүүлэн ярилцаж өгүүлбэр хоорондын код солилт хийсэн байна.

⁶ “College” гэх үг нь их сургуультай төстэй утгатай, бакалаврын зэрэг олгодог дээд боловсролын байгууллагыг хэлдэг.

Жишээ 2.

А: Thank you very much (маш их баярлалаа). Яах гээд байгаа юм бэ?

Б: I don't know (би мэдэхгүй).

А: Чи энийг нь сонгосон юм уу?

Б: Яа гэлээ?

А: Чи чинь хонхны цаг эхлэхээр 2 өгүүлбэр асуусан биз дээ.

Б: Asking this, no this. I was doing, I don't know. Doing this self check. (Үүнийг асууж байна, үгүй энийг. Би хийсэн, мэдэхгүй байна. Өөрийгөө шалгаж байна.)

Энэ тохиолдолд 6-р ангийн эрэгтэй, эмэгтэй сурагчид англи хэлний хичээлийн тухай ярилцаж байсан бөгөөд даалгаврыг тайлбарлах үүднээс өгүүлбэр хоорондын код солилт хийж байна.

7. Судалгааны үр дүн

ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын хэл ярианд хийсэн код солилтын судалгаанаас дараах зүйлс ажиглагдав. Үүнд:

- Домэйн (талбар)-ы хувьд: Өмнөх судлаачдын 5 домэйноос найз нөхөд, боловсролын домэйн бидний судалгаанд тохиромжтой байсан бөгөөд асуулгад 49 сурагч оролцсоноос 30 (61%) нь өдөр тутмын яриандаа англи үг хэрэглэдэг, 41 (84%) нь найзуудтайгаа, 39 (80%) нь сошиал орчинд код солилт хийдэг байна.
- Шалтгааны хувьд: Сайн дурын, ойр дотно байх, хөгжилтэй байх, дагаж ярих, зорилготой байх (тухайн нөхцөлд илүү тохиромжтой хэлээр юм уу үе тэнгийнхэн нь түгээмэл хэлдэг үгээр) гэсэн код солилтын шалтгаанууд байна.
- Төрлийн хувьд: нөхцөл байдлын, хаяг шошгын, өгүүлбэрийн доторх, өгүүлбэр хоорондын гэх байдлаар илэрч байна. Өгүүлбэр доторх код солилтын 116 өгүүлбэр цуглуулснаас монгол хэлний өгүүлбэрийн бүтцэд англи үг хэрэглэсэн 95 өгүүлбэр (82%), англи хэлний өгүүлбэрийн бүтцэд монгол үг хэрэглэсэн нь 3 өгүүлбэр (3%), англи үгэнд монгол дагавар, нөхцөл залгасан нь 18 өгүүлбэр (15%) байна. Үүнээс монгол хүүхдүүд монгол хэлээрээ ярихдаа англи хэлнээс үг, богино өгүүлбэр зэрэг бага нэгж авч ашигладаг явдал түгээмэл байдаг нь харагдаж байна.

8. Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1-д: “Монгол Улсад монгол хэл нь албан ёсны хэл мөн” гэж Монгол Улсад хэрэглэх албан ёсны хэл бол монгол хэл болохыг хуульчлан заасан байдаг. Код солих үзэгдэл нь хоёр болон түүнээс олон хэлтэй хүмүүст илэрдэг нийгмийн үзэгдэл боловч албан ёсны нэг хэлтэй манай улсын хүүхэд залуус гадаад хэл сурах болсонтой холбоотойгоор код солих үзэгдэл нийгмийн харилцаанд түгээмэл ажиглагдах болсон байна. Үүнээс, юуны өмнө энэхүү үзэгдэл монгол хэл шинжлэлд зайлшгүй судлах шаардлагатай нийгэм хэл шинжлэлийн нэг судлагдахуун болсон нь тодорхой байна. Цаашилбал, эх хэлний дархлаа, аюулгүй байдал, үнэлэмж, гадаад хэл сурах судлах эрх чөлөө, нас, заах арга зүй гэх мэт олон асуудалтай холбон судалж, улмаар эх хэлний болон гадаад хэлний бодлогод тусгах нарийн асуудал нэгэнт болсон байна.

Ном зүй

А. Монгол хэлээр

Оюунтана. (2014). *Монгол хятад хэлний код солилтын тухай судалгаа*, 42-52. [Oyuntana. *Mongol hytad helnii kod soliltiin tuhai sudalгаа* [A research on Mongolian and Chinese languages code switching summary].

Мөнхцэцэг, Н., Амартүвшин, Н., Гэрэлмаа, Г., Батбямба, Т., Золжаргал, Б., Гэндэнпил, Х. (2023). *Үгийн учир*. Улаанбаатар: Соёмбо Принтинг хэвлэлийн газар. [Mönhtsetseg, N., Amartüvshin, N.,

Gerelmaa, G., Batbyamba, T., Zoljargal, B., Gendenpil, H. *Ugiin uchir* [The semantics of a word]. Ulaanbaatar: Soyombo printing. 2023.]

Б. Гадаад хэлээр

- Bai Naren.** (2013). A Study of Code-switching between Mongolian and Chinese from the Perspective of Register Theory. 23.
- Ephie Konidaris.** (2004). Code-switching among Trilingual montrealers: French, English and a Heritage language. *United States: National Council of Less Commonly Taught language*. 32. Retrieved from www.ncolctl.org/files/Code-Switching.pdf
- Erman Boztepe.** (2003). Competing Theories and Models. *Teachers College, Columbia University*. 11. Retrieved from <https://journals.library.columbia.edu/index.php/SALT/article/view/1626/670>.
- Fernandette M. Gamotin,** (2021). Speaking performance and the types of code switching of senior high school students. London, *United Kingdom: A-Kindi Centre for Research and Development*. 41-42. Retrieved from www.researchgate.net/publication/355795632_Speaking_Performance_and_the_Types_of_Code-switching_of_Senior_High_School_Students.
- George McDaniel.** (1994). IBM Dictionary of computing. 214.
- Janet Holmes, Nick Wilson.** (2017). An introduction to sociolinguistics, Routledge (Taylor, Francis group). 1-25. <https://doi.org/10.4324/9781315728438>
- Putu Findi Desi Wibiani.** (2021). Code-switching analysis on youtube chanel #Nebeng boy by boy William. *Udayana University, Denpasar, Bali, Indonesia* 300-301. Retrieved from www.researchgate.net/publication/354410979_Code_Switching_Analysis_on_Youtube_Channel_NebengBoy_by_Boy_William.
- Shafiyah Mohamad Khalil, Mohammad Shazie Zaini Mohd Shahril Firdaus.** (2018). Inter-sentential and intra-sentential code switching in parliamentary debate. 30-31. Retrieved from <https://ir.uitm.edu.my/id/eprint/42812/1/42812.pdf>
- Sholihatul Hamidah Daulay, Ahmad Husein Nasution, Fitri Randia Ningsih, Hotma Berutu, Novia Robeitah Irham, Rifaatul Mahmudah.** (2024). Code switching in the social media era: A Linguistic analysis of instgaram and tik tok users. 374. Retrieved from www.researchgate.net/publication/383171193_Code_Switching_in_the_Social_Media_Era_A_Linguistic_Analysis_of_Instagram_and_TikTok_Users.

В. Цахим эх сурвалж

Retrieved from <https://www.oxfordlearnersdictionaries.com/>

Г. Хууль тогтоомж

Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг